



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/33

Эг

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн урьдчилсан үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийг 2025 оны 05 дугаар сарын 15, 16- ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Даргаар:	Б.Төрмөнх	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн даргаар:	Э.Цацрал	Татварын улсын байцаагч
Гишүүдэд:	Л.Мөнхчулуун	Хурх багийн Засаг дарга
	Б.Бадамгарав	Норовлин багийн Засаг дарга
	Д.Хонгорзул	Онон багийн Засаг дарга
	В.Чулуун	Барх багийн Засаг дарга
	Б.Ариунболор	Хууль эрх зүйн мэргэжилтэн
	Р.Болор-Эрдэнэ	Хэсгийн төлөөлөгч, дэслэгч
	Б.Мөнгөнтөгс	Цагдаагийн дэд ахлагч

3. Авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийн бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Техникийн үзлэгийн өмнө авто тээврийн хэрэгслийн албан татвар хураах ажлыг бүрэн барагдуулахыг татварын улсын байцаагч (Э.Цацрал)-д даалгасугай.

5. Хуваарьт өдөр хэв журам сахиулах, авто тээврийн болон агаарын бохирдлын төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байхыг хэсгийн төлөөлөгч, дэслэгч /Р.Болор-Эрдэнэ/, цагдаагийн дэд ахлагч /Б.Мөнгөнтөгс/ нарт үүрэг болгосугай.

232501065

6. "Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай" хуулийн дагуу бүх тээврийн хэрэгслийг хариуцлагын даатгалд хамруулах зорилгоор даатгалын компаниудын төлөөлөгч нарыг ажиллах нөхцөлөөр хангах, тээврийн үзлэгийн үйл ажиллагааны дүнг танилцуулахыг комиссын дарга (Б.Төрмөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ